

# "ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 01 сарын 27 өдөр

Дугаар № 01

Улаанбаатар хот

Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон  
санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах  
зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9, 62.1.15 дахь заалтыг тус  
тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Дорнод бүсийн эрчим хүчний систем" төрийн өмчит хувьцаат компанийн  
2020 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайланг "Хангалттай" гэж үнэлсэн  
Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг зүйтэй гэж үзсүгэй.

2. Компанийн 2020 оны үйл ажиллагаанд дүгнэлт хийж, зорилтот түвшинг  
биелүүлэх, өртөг зардлыг бууруулах, үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлэх, санхүү,  
төлбөрийн чадварыг сайжруулах, аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх шаардлагатай  
арга хэмжээг авч ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлд даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ИТГЭМЖЛЭГДСЭН  
ТӨЛӨӨЛӨГЧ

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМЫГ  
ТӨЛӨӨЛЖ  
  
УХА0558  
Б.НАСАНТОГТОХ

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫГ  
ТӨЛӨӨЛЖ  
  
Ц.БАЯР-ЭРДЭНЭ  
6058159 - 1118262933

# "ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 04 сарын 27 өдөр

Дугаар № 02

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны  
ажлын тайлангийн тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.15 дахь заалтыг үндэслэн  
ТОГТООХ нь:

1. "Дорнод бүсийн эрчим хүчний систем" төрийн өмчит хувьцаат компанийн  
Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны үйл ажиллагааг "Хангалттай" гэж үзсүгэй.

2. Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэн компанийн  
өмнө тавигдсан зорилтыг ханган биелүүлэх, өр авлагыг барагдуулах, бараа, ажил,  
үйлчилгээ худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулахад хяналт  
тавьж, хариуцлагатай, идэвх зүтгэлтэй, санаачилгатай ажиллахыг Төлөөлөн  
удирдах зөвлөлд даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ИТГЭМЖЛЭГДСЭН  
ТӨЛӨӨЛӨГЧ

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМЫГ  
ТӨЛӨӨЛЖ:



Б.НАСАНТОГТОХ

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУДАЛТЫН ГАЗРЫГ  
ТӨЛӨӨЛЖ:



Ц.БАЯР-ЭРДЭНЭ

6098169 / 111872953

# "ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 04 сарын 27 өдөр

Дугаар № 03

Улаанбаатар хот

## Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны зардлын төсөв батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13, 62.1.15 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Дорнод бүсийн эрчим хүчний систем" төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны зардлын төсвийг хавсралт ёсоор баталсугай.

2. Батлагдсан төсвийн зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Цалин урамшууллын болон Аудитын хороонд тус тус даалгасугай.

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ИТГЭМЖЛЭГДСЭН ТӨЛӨӨЛӨГЧ

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМЫГ  
ТӨЛӨӨЛЖ:

  
УХА0558  
Б.НАСАНТОГТОХ

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫГ  
ТӨЛӨӨЛЖ

  
Ц.БАЯР-ӨРДЭНЭ  
6098109 \* 1118282963

“ДБЭХС” ТӨХК-ийн хувьцаа эзэмшигчдийн  
хурлын 2021 оны 4 дүгээр сарын 27-ны  
өдрийн 03 дугаар тогтоолын хавсралт



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
2021 ОНЫ ЗАРДЛЫН ТӨСӨВ

д/д	Зардлын үзүүлэлт	2021 төлөвлөгөө			
		Хүн	Тарифт	Сард /мян.төг/	Жилд /мян.төг/
1	<b>1. Цалингийн зардал</b>	<b>10</b>		<b>5,520.0</b>	<b>83,400.0</b>
1.2	ТУЗ-ын дарга	1	750,000	750.0	9,000.0
1.3	Гишүүд	8	700,000	5,600.0	67,200.0
1.4	Нарийн бичгийн дарга	1	600,000	600.0	7,200.0
2	<b>2. НДШимтгэл</b>			<b>1753.485</b>	<b>12,093.0</b>
3	<b>3. Томилолтын зардал</b>				<b>6,564.6</b>
3.1	Унаа	9	214,700	1,932.3	3,864.6
3.2	Байр, хоол /хүн-хоног/	9	50,000	1,350.0	2,700.0
4	<b>4. Бичиг хэрэг</b>			<b>12,000.0</b>	<b>180.0</b>
4.1	Бичиг хэрэг			15.00	180.00
5	<b>5. Хурлын зардал</b>			55.00	660.00
	<b>ДҮН</b>			<b>8,574.8</b>	<b>102,897.6</b>

# "ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 04 сарын 27 өдөр

Дугаар № 04

Улаанбаатар хот

## 2020 оны ногдол ашгийн тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.6, 62.1.15 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:


1. "Дорнод бүсийн эрчим хүчний систем" төрийн өмчит хувьцаат компанийн 2020 оны аудитлагдсан санхүүгийн тайлан тэнцлээр 302,445,922.67 /гурван зуун хоёр сая дөрвөн зуун дөчин таван мянга есөн зуун хорин хоёр төгрөг жаран долоон мөнгө/ төгрөгийн ашигтай ажилласан тул ногдол ашиг 15 хувиар тооцож улсын төсөвт төвлөрүүлэхийг гүйцэтгэх удирдлагад үүрэг болгосугай.

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ИТГЭМЖЛЭГДСЭН ТӨЛӨӨЛӨГЧ

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМЫГ  
ТӨЛӨӨЛЖ:

  
УХА0558  
Б. НАСАНТОГТОХ

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫГ  
ТӨЛӨӨЛЖ:

  
Ц. БАЯР-ЗҮРДЭНЭ

0098169 1118262983

# "ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 04 сарын 27 өдөр

Дугаар № 05

Улаанбаатар хот

## Гүйцэтгэх захирлын контрактыг дүгнэх тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.15, 84.4.2 дахь заалт, Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2019 оны 02 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Эрчим хүчний салбарын төрийн өмчит компанийн гүйцэтгэх захиралтай байгуулсан контрактыг дүгнэх, урамшуулал олгох түр журам"-ын 2.1, 2.6, 2.7, 2.8 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Эрчим хүчний сайдын 2021 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн А/80 дугаар тушаалаар байгуулагдсан Ажлын хэсгийн дүгнэлтийг харгалзан "Дорнод бүсийн эрчим хүчний систем" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирлын 2020 оны контрактын биелэлтийг "Хангалттай" гэж дүгнэсүгэй.

2. Контрактаар хүлээсэн үүргээ "Хангалттай" биелүүлсэн гүйцэтгэх захирлын контрактыг 1 /нэг/ жилээр сунгахыг Төлөөлөн удирдах зөвлөлд удирдамж болгосугай.

3. Дулаан, цахилгааны эрчим хүчний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн орлогын төлөвлөгөөг биелүүлэх, өр, авлагыг барагдуулах, үр ашгийг дээшлүүлэх, зардал талаар удирдлага зохион байгуулалтын бодитой арга хэмжээ авч ажиллахыг Гүйцэтгэх захирал /Г.Отгонбаатар/-д үүрэг болгосугай.


4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хувьцаа эзэмшигчдийн хурлын нарийн бичгийн дарга /Л.Сэлэнгэ, Б.Нармандах/ нарт тус тус үүрэг болгосугай.

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ИТГЭМЖЛЭГДСЭН ТӨЛӨӨЛӨГЧ

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМЫГ  
ТӨЛӨӨЛЖ:

  
УХА0558  
Б.НАСАНТОГТОХ

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫГ  
ТӨЛӨӨЛЖ:

  
Ц.БАЯР-ЭРДЭНЭ  
6098160 > 1118267993

# "ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2011 оны 04 сарын 27 өдөр

Дугаар № 06

Улаанбаатар хот

Компанийн өөрийн хөрөнгийн дүнг  
нэмэгдүүлэх, дүрэмд  
өөрчлөлт оруулах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1, 62.1.3, 62.1.16 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн хавсралтад заасан 2,722,801,725.77 /хоёр тэрбум долоон зуун хорин хоёр сая найман зуун нэг мянга долоон зуун хорин таван төгрөг далан долоон мөнгө/ төгрөгийн хөрөнгийн эх үүсвэрийн дүнгээр компанийн өөрийн хөрөнгийн дүнг нэмэгдүүлэхийг Гүйцэтгэх захирал /Г.Отгонбаатар/-д зөвшөөрсүгэй.

2. "Дорнод бүсийн эрчим хүчний систем" төрийн өмчит хувьцаат компанийн дүрмийн 03 дугаар зүйлийн 3.1 дэх заалтад "нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 480 105 358 ширхэг энгийн хувьцаатай" гэснийг 508 256 274 ширхэг энгийн хувьцаатай" гэж өөрчилсүгэй.

3. "Дорнод бүсийн эрчим хүчний систем" төрийн өмчит хувьцаат компанийн өөрийн хөрөнгийн дүнд орсон өөрчлөлтийг компанийн дүрэмд тусган холбогдох байгууллагуудад бүртгүүлэхийг Гүйцэтгэх захирал /Г.Отгонбаатар/-д даалгасугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хувьцаа эзэмшигчдийн хурлын нарийн бичгийн дарга /Л.Сэлэнгэ, Б.Нармандах/ нарт үүрэг болгосугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ИТГЭМЖЛЭГДСЭН  
ТӨЛӨӨЛӨГЧ

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМЫГ  
ТӨЛӨӨЛЖ:

  
УХА0588  
Б.НАСАНТОГТОХ

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫГ  
ТӨЛӨӨЛЖ:

  
Ц.БАЯР-ЭРДЭНЭ  
УХА0169 ▲ 1118262955

"ДБЭХС" ТӨХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн  
хурлын 2021 оны 4 дүгээр сарын 27-ны  
өдрийн 578 дугаар тогтоолын хавсралт



**"ДБЭХС" ТӨХК-ийн өөрийн хөрөнгийн дүнгийн өөрчлөлт**

д/д	Төрийн өмчийн дүн	Тогтоол шийдвэрийн дугаар	Бүртгэлийн дүн
1	2020 оны 01 дүгээр сарын 01-нээрх төрийн өмчийн дүн		48,102,825,726.66
2	Нэмэгдсэн: Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Дорнод, Сүхбаатар аймгийн сумдын 0.4, 0.22кВ-ын модон тулгууртай ЦДАШ-ыг төмөр бетон тулгууртай СИП шугамаар солих, дэд станцын өргөтгөл хийгдсэн	ТӨБЗГ-ын 2020 оны 11 дүгээр сарын 24ны өдрийн 578 дугаар тогтоол	2,722,801,725.77
3	Тайлан тэнцэлд тусгах төрийн өмчийн дүн		50,825,627,452.43
4	Нэрлэсэн үнэ		100
5	Хувьцааны тоо		508 256 274